



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/152

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 08 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А230/127 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан журамд нийцүүлэн гаргасан, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан "Усан сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүс"-ийн дэглэмийг мөрдүүлэх, усны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

| | | |
|-----------------------|----------------|--|
| Ажлын хэсгийн ахлагч: | Б.Дархантөр | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга |
| Нарийн бичгийн дарга: | Б.Мөнхжаргал | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн байгаль орчин, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн |
| Гишүүд: | Г.Мөнх-Эрдэнэ | БОАЖГ-ын Геологи, уул уурхай, тусгай хамгаалалт, хариуцсан мэргэжилтэн |
| | Г.Баярцэцэг | БОАЖГ-ын Орчны бохирдол, усны асуудал хариуцсан мэргэжилтэн |
| | Б.Золбоожаргал | Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, газрын харилцаа, геодези, зурагзүй хариуцсан байцаагч |
| | Н.Болор-Эрдэнэ | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Кадастрын мэргэжилтэн |
| | Т.Бямбажаргал | Онон голын сав газрын захиргааны, Газарзүйн мэдээлэл, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн |

2//.

Б.Урансувд

Биндэр сумын газрын даамал

Б.Баясгалан

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Зүүн
бүсийн салбарын захирал

2. Ажлын хэсгийн ажиллах чиглэлийг хавсралтаар баталсугай.

3. Ажлын хэсгээс боловсруулсан саналаа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Дархантөр/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Ажлын хэсгийн ажиллах чиглэл

- Усны тухай хуулийн хэрэгжилт ямар байгаа, газар ашиглалтын хувьд усан сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүсийн дэглэм хэрэгжиж байгаа эсэх, зөрчил байгаа эсэх
- Зөрчил байгаа бол түүнийг арилгах боломж байгаа эсэхийг судлах, хэлэлцэх
- Сумдын шийдвэр гаргагчдын ойлголтыг сайжруулах, сургалт, уулзалт хийх бусад сумдын шийдвэр гаргагчдыг хамруулах
- Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд нь дэглэмд нийцэж байгаа эсэхийг тодорхойлох
- Тогтоол хэрэгжиж эхэлснээс хойш онцгой хамгаалалтын бүсэд газар олголт хийгдсэн эсэхэд хяналт тавих
- Шаардлагатай газруудад газар дээр нь очиж хэмжилт хийх
- Цаашид усны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад зориулсан зөвлөмж, хийх ажлын төлөвлөгөө гарган аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлэх